

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-

1. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ 3-

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 17 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, Л.Оюун-Эрдэнэ, С.Зулпхар, Л.Гантөмөр;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Ө.Шижир, Т.Доржханд, Н.Номтойбаяр, О.Цогтгэрэл, Л.Энх-Амгалан.

Нэг. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Итгэлт, мөн газрын Төмөр замын тээврийн хэлтсийн дарга Д.Мөнхбат, Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, мөн хэлтсийн ахлах шинжээч Б.Цэнд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 04 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 21 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
18 цаг 17 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Ингээд Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг та бүхэнд танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн байна. Баярмагнай Баярбаатар гишүүн ирсэн байна. Лхагвын Мөнхбаатар гишүүн ирсэн. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн. Дашзэвэгийн Амарбаясгалан гишүүн ирсэн. Жудагийн Баярмаа гишүүн ирсэн. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ, Жудагийн Баярмаа гишүүн ирсэн. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн. Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн. Ингээд Батын Батбаатар гишүүн хүрэлцэн ирсэн.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Нэг асуудал байна.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 2024 оны 12 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Та бүхэнд бас ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг орж ирсэн байна.

С.Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Итгэл Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга, Д.Мөнхбат Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын Тээврийн хэлтсийн дарга, С.Мядагмаа Зам, тээврийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Б.Цэнд Зам, тээврийн яамны Хуулийн хэлтсийн ахлах шинжээч.

Ингээд танилцуулгыг та бүхэнд уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хурал нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэхэд хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхдугаар хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг тогтоолын төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ийм танилцуулга байна.

Танилцуулгатай холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна.

Танилцуулгатай холбоотойгоор санал хэлэх гишүүд байна уу?

Алга байна.

Ингээд Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир түрүүн уншсан тээ? Сандаг-Очир гишүүн уншчихъя.

Ингээд хэлэлцэх асуудал бол дууссан тул “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдааныг хаасныг мэдэгдье.

18.21 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

